



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 11 өдөр

Дугаар A/23

Хархорин сум

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дахь заалт, 21.3 дахь хэсэг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 02 дугаар сарын 29-ны өдрийн (Төлөвлөгөө батлах тухай) 19/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтныг шимэгчтэх өвчинөөс эмчлэн сэргийлэх угаалга, туулгалт, боловсруулалт, өвөлжөө, хаваржааны газрыг халдвартгүйтгэх ажлыг зохион байгуулах, хийж гүйцэтгэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Э.Нарангарав (Мал эмнэлгийн тасгийн дарга)

Гишүүд: Ц.Пүрвээ (“Дэлийн бүрд” мал эмнэлгийн эзэн)

А.Сайнбилэг (“Аяган зураа” мал эмнэлгийн захирал)

Т.Алтангэрэл (1 дүгээр багийн Засаг дарга)

Р.Сүхбат (2 дугаар багийн Засаг дарга)

Д.Батчулуун (3 дугаар багийн Засаг дарга)

Г.Отгонбаяр (4 дүгээр багийн Засаг дарга)

Б.Ганхуяг (5 дугаар багийн Засаг дарга)

Л.Төгөлдөр (6 дугаар багийн Засаг дарга)

О.Батсүх (7 дугаар багийн Засаг дарга)

П.Нэндарам (8 дугаар багийн Засаг дарга)

2. Мал амьтныг шимэгчтэх өвчинөөс эмчлэн сэргийлэх, угаалга, туулгалт, боловсруулалт, өвөлжөө, хаваржааны газрыг халдвартгүйтгэх ажлыг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 10-ны өдөр хүртэл хийж гүйцэтгэн, дүн мэдээг тухай бүр танилцуулахыг мал эмнэлэг, үйлчилгээний нэгжийн их эмч (Ц.Пүрвээ), (А.Сайнбилэг) нарт даалгасугай.

3. Мал амьтныг шимэгчтэх өвчинөөс эмчлэн сэргийлэх угаалга, туулгалт, боловсруулалт, өвөлжөө, хаваржааны газрыг халдвартгүйтгэх ажлын зарыг малчдад хүргэж, товлосон газарт мал сүргийг бэлэн байлгах ажлыг зохион байгуулахыг багийн Засаг дарга нарт, товлосон газар тогтоосон хугацаанд арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулахыг мал бүхий иргэн, малчдад тус тус үүрэг болгосугай.

401100045

4.Ажлын явц, технологийн мөрдөлт, зохион байгуулалт, мал сүргийн хамрагдалтад байнгын хяналт тавин ажиллахыг мал эмнэлгийн тасгийн дарга (Э.Нарангаав)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ОДГЭРЭЛ

